

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

2022.11.30

Сайншанд

/2022.11.11/ Дорноговь аймгийн ГХУСАЗСЗ-ийн 6 дугаар хуралдаан зохион байгуулагдлаа. Хуралдаанаар доорх асуудлуудыг хэлэлцэж баталсан.

1.Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор “Таны эрх миний эрхээр хязгаарлагдана” сэдэвт сургалт зохион байгуулсан тайланг сонсох

2.Хүүхэд хөгжил-2022 зорилтот жилийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг бий болгох зорилгоор “Эрүүл аж төрөхүй” эрүүл мэндийн хичээлийн анхдугаар олимпиад зохион байгуулах зардалд зориулан дэмжлэг үзүүлэх

3.Сургуулийн орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийн сургагч багш бэлтгэх, тэднээр дамжуулан сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор аймгийн хэмжээнд 30 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэх сургалт зохион байгуулахад зардал гаргах

4.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран малчид, мал бүхий иргэд, олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэх “МАЛ МАХ-2022” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахад зардал гаргах

5.Тагнуулын ерөнхий газрын Замын-Үүд дэх газар нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байнгын бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан албан хаагчдыг албаны тусгай бэлтгэл сургуулилтад хамруулах, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын албан хаагчдад сургалт, дадлагын арга хэмжээ зохион байгуулахад зориулан дэмжлэг үзүүлэх

/2022.11.14/ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” хамтарсан багийн үндэсний V чуулганд аймгийн ИТХ-ын дарга, сумдын ИТХ-ын дарга нар хамрагдлаа.

Тус чуулганд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хамгаалах чиг үүрэг бүхий улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 735 хамтарсан багийн 800 гаруй төлөөлөгчид оролцож байна.

Чуулганаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын хамтын ажиллагааг

бэхжүүлэх, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүжилтийг шийдвэрлэх талаар хэлэлцэж байна.

Тус чуулганд аймгийн ИТХ-ын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-ын дарга нар оролцож байна.

Уг чуулганы үеэр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2021, 2022 онд олгосон санхүүжилтээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний "САЙН ТУРШЛАГА" сэдвээр Алтанширээ сумын Засаг дарга, Хамтарсан багийн ахлагч Н.Бүрэнтэгш танилцуулга хийлээ.

/2022.11.16/ “НОГООН ГЭРЭЛ - ЦАГААН ШУГАМ 2022” ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Улаан загалмайн нийгэмлэг, Боловсрол, шинжлэх ухааны газар, Авто сургуулиудтай хамтран хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадал олгох, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ногоон гэрэл - Цагаан шугам 2022” тэмцээнийг аймгийн ЕБС-иудын дунд зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга Б.Гантөмөр, аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, хошууч Б.Батцолмон нар нээлтийн арга хэмжээнд оролцож сурагч хүүхдүүд, багш нарт амжилт хүссэн юм.

Тэмцээнд 13 багийн 156 сурагч оролцсоноос:

- Тэргүүн байранд Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн Б.Төрмөнх ахлагчтай “Шинэ эхлэл” баг,
- Дэд байранд Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Д.Эрхэс ахлагчтай “Цагаан Шонхор” баг,
- Гутгаар байранд Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн З.Идэрболд ахлагчтай “Аравт” баг,
- Тусгай байранд Замын-Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн О.Төгөлдөр ахлагчтай “Ирээдүй” баг тус тус шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Мөн “Уран зохицуулагч”-аар Замын-Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Ирээдүй багийн О.Төгөлдөр,

“Шилдэг багш”-аар Хатанбулаг сумын ЕБ-ын сургуулийн багш С.Цэцэгмаа нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

/2022.11.23/ АЙМГИЙН ИТХ-ЫН ЗӨВЛӨЛИЙН 5 ДУГААР ХУРАЛ ХУРАЛДЛАА

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 5 дугаар хурал 85,7 хувийн ирцтэй хуралдаж, дараах асуудлыг хэлэлцлээ.

1. Аймгийн ИТХ-ын хороод ажлын хэсгийн бүрэлдэхүүн сумдад ажилласан талаар тайлан мэдээллийг сонсох
2. Аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдааны тов тогтоох тухай хэлэлцэж, 2022.12.03-04-ний өдрүүдэд зохион байгуулахаар баталлаа.

/2022.11.26/ “Иргэний андгай” өргөх ёслолд ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Батсугир оролцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор жил бүр зохион байгуулдаг “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг 2022.11.26-ны өдөр зохион байгуулж, ёслолын арга хэмжээнд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Батсугир оролцож андгай өргөж буй сурагчдад мэндчилгээ дэвшүүллээ.

Энэ өдрийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд суманд Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээнд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авах өсвөр үеийн төлөөлөл 60 хүүхэд оролцон тангараг өргөж төрийн тугандаа мөргөж хүндэтгэл үзүүллээ.

Аймгийн ИТХ-ын даргын шагнал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын 1 Хүндэт өргөмжлөл, 8 Өргөмжлөл гарсан байна.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж

Аймгийн ИТХ-ын даргын нийт 11 захирамж гарснаас ангилбал Зардал гаргах тухай-8, Хүндэтгэл үзүүлэх тухай-1, Ээлжит хуралдааны тов зарлах тухай-1, Буцалтгүй тусламж олгох тухай-1 захирамж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн 4 тушаал гарсан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН МЭДЭЭ

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Хүний нөөцийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйл ажиллагааны тушаал 9, боловсон хүчний тушаал 10 баталсан байна.

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А- 40, Захирамж Б- 1, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А- 9, Тушаал Б-10 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 40 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байхршуулсан. байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 561 албан бичиг ирснээс 43 нь хугацаатай албан бичиг ирсэн. Үүнээс 14 албан бичиг хугацаа болоогүй бусад 39

албан бичиг хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Бусад байгууллагад явуулсан 86 албан бичиг гарсан байна.

-Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал **2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 19-ний өдөр** хүртэл Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Мандах, Сайхандулаан сумдад ажилласан. Энэ үеэр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулах, “Хөгжлийн төлөө хамтдаа-II” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулж, ард иргэдтэй уулзалт зохион байгуулан санал хүсэлтийг сонсож, орон нутгийн цаг үеийн байдал, сумын Засаг даргын Тамгын газар, харъяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, тухайн орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын болон өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шийдвэрлэн ажилласан.

Иргэдтэй уулзах уулзалтад **1581** иргэн оролцож, аймгийн Засаг дарга **436** иргэний асуултанд хариулт өгч, шийдвэрлэсэн. Мөн Засаг даргын ажлын хэсэг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” өдөрлөгийг зохион байгуулж 7 байгууллагын 19 үйлчилгээг **2598** иргэнд үзүүлсэн байна.

-Агентлаг байгууллагын дарга нарын хурлыг 11 дүгээр сарын 01, 30-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газраар мэдээлэл танилцуулж, аймгийн Засаг дарга үүрэг чиглэл өгсөн.

-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанд оруулах асуудлын жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэн ажилласан. Үүнд:

- 1.Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
- 2.Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
3. “Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”- ийн хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ
4. Аймгийн дэд болон зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
5. Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт, танилцуулга
6. Аймгийн 2023 оны төсөв батлах тухай
7. Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай
8. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
9. “Ханбаянзүрх хайрхан уул, хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч, аялагчдын нийтээр дагаж мөрдөх журам” батлах тухай
10. Дорноговь аймгийн Сайншанд сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай
11. Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай

12. Орон нутгийн өмчийн 2022 оны тооллогын дүн мэдээний тухай
13. Орон нутгийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөний тухай
14. Нэрэмжит болгох тухай
15. Бусад асуудал

Өргөдөл, гомдол, шагнал:

2022 оны 11 дүгээр сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж 52 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс:

Бичгээр -32,
Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – 20

Ирсэн нийт өргөдөл, гомдол, саналууд 33 нь шийдвэрлэгдэж, 19 өргөдөл нь шийдвэрлэхээр судлагдаж байна.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 27 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч дэмжих санал авахаар харъяалах төрийн төв байгууллагад хүргүүлж, дэмжсэн санал ирсэн шагналын материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 86 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргын “Жуух”-аар 20 иргэнийг, “Өргөмжлөл”-өөр 48 иргэнийг шагнах тухай захирамж боловсруулж батлуулав.

Гадаад харилцааны чиглэлээр:

- Япон улсын Шизуока мужаас Ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагааны хүрээнд 7 албаны хүнийг хүлээн авч 5 өдрийн үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.
- ОХУ-аас хүрэлцэн ирсэн төлөөлөгчдийг хүлээн авч хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Япон улсын Шизуока мужтай хамтын ажиллагааны хүрээнд “Сурагч солилцоо” хөтөлбөрийн бэлтгэл ажлыг хангаж, хамрагдаж буй 25 сурагч, 2 багштай хамт нэгдсэн байдлаар Япон улсын Элчин сайдын яаманд виз мэдүүлж баталгаажсан.
- 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд шадар сайд, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Зүүн хойд Азийн бүсийн төв, Дэлхийн боловсрол, сургалтын институт (GETI)-ээс хамтран зохион байгуулсан “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот 2030” санаачилгын зорилго, чиглэл, цахим платформд нэгдэх үйл ажиллагаа болон Монгол Улсын нийслэл хот, аймгийн төвүүдийн тус санаачилгыг үргэлжлүүлэх, үүрэг амлалтаа бататгах арга хэмжээний Цахим вебинарт оролцов.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-ын цаг үеийн 33 мэдээ аймгийн сайт болон цахим хуудсанд байршуулсан.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 11 байгууллагын 41 албан хаагчид өгч ажилласан.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Гадагш чиглэсэн үйл ажиллагаа:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн дээд Комиссарын албаны ази номхон далайн хэлтсийн Монгол Улсыг хариуцсан мэргэжилтэн себастьян гиёогийн хамтаар орон нутагт ажиллаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр, аймгийн цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байр, сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай танилцсан бөгөөд аймгийн Засаг дарга хүлээн авч уулзаж, хэлтсийн дарга мэдээлэл хүргэн ажиллав.

Дорноговь аймгийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 14 сумын засаг даргын тамгын газрын даргаар ахлуулсан орон тооны бус зөвлөлийн гишүүдтэй арга зүйн зөвлөгөө, тэдгээрийн чиг үүрэгт мэдээлэл өгөх цахим сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн засаг даргын тамгын газраас аймгийн прокурорын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 14 сумын орон тооны бус зөвлөлийн гишүүдэд цахим сургалт зохион байгуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт орон нутгийн холбогдох албан тушаалтнууд оролцлоо. Монгол улсын ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар зарлигийн хавсралтаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ыг шинэчлэх ажлын хүрээнд зохион байгуулж буй тус уулзалт, хэлэлцүүлэгт аймгийн засаг даргын тамгын газрын дарга Н.Хонгорзул, орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн оролцож, мэдээлэл солилцсон.

Үндэсний аюулгүй байдлыг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгүүдэд “2022 онд аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайланг үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр-т албан бичгээр хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, тэдний эцэг, эх, багш, нийгмийн ажилтны оролцоог нэмэгдүүлэх, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүүхдээс хүүхдэд аргачлалын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн засаг даргын 2022 оны а/634 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт сургуулиудын дэргэд “өсвөрийн сэргийлэгч” бүлгэм байгуулан ажиллуулахаар шийдвэрлэсэн байдаг. Энэхүү бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор аймгийн здтг-аас цагдаагийн газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран “өсвөрийн сэргийлэгч-2022” тэмцээнийг аймгийн засаг даргаас баталсан удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 12-с 11 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Хүүхэд... Хүчирхийлэл... Хүн бүхэнд хамаатай...
“зогсохгүй” luuya enkhamgalan aajimbaug duurenjargal нартай хамтран бага насны хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд контентыг бэлтгэсэн.

“Хүүхэд бүр хайрлагдах эрхтэй” аяны хүрээнд хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнчлэн бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудыг татан оролцуулах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл соёлын болон хувийн салбарын 36 байгууллагын дунд нөлөөллийн аяны дэвтэр аялуулах ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж байна.

Нийгмийн ухааны багш, нийгмийн ажилтнуудын дунд зарласан төсөл сонгон шалгаруулах чиглэлээр 1 захирамж, холбогдох бусад асуудлаар 2 тушаал боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж эхний 3 байрыг шалгаруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигаар нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсан.

Зарлигийн хүрээнд хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх, согтууруулах ундааны хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, цагдаагийн ерөнхий газраас хамтран 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд “намайг алгас” соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаатай холбогдуулан аяныг сурталчлан таниулах, нэгдэх асуудлаар төрийн болон хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад чиглэл хүргүүлж, албаны цахим хуудсанд холбогдох мэдээ мэдээлэл байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Байгууллагын албан хаагчид маань мөн аян нэгдэж, холбогдох мэдээ мэдээллийг хуваалцахыг уриалж байна.

Дотоод үйл ажиллагаа:

ОСНААГ байгуулах ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, аймгийн засаг даргад танилцуулах бэлтгэл ажлыг ханган, гурван талт гэрээний төсөл боловсруулан ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг тус тус тайлагнаж ажиллалаа.

Хүний эрх, жендэр, ардчилал, оролцоо, засаглал, байгаль орчны чиглэлээр 2018-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд албан бичгээр хүргүүлсэн.

2018-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээ болон 2023-2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хэлтсүүдээс судалгаа авч нэгтгэсэн.

2022 оны 12 дугаар сард Хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөн, хүний эрхийн өдөр, архивын ажилтан нарийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулахтай холбоотойгоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Шүүх хурал:

Иргэн Д.И нэхэмжлэлтэй Захиргааны хэрэгийн шүүх хуралд оролцож захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал, давж заалдах шатны шүүх хурал, дээд шүүхийн гээд 3 шатны шүүхээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

Ч Б ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг анхан шатны шүүх хурал, давж заалдах шүүх хурал болж амжилттай шийдвэрлэгдээд байна.

ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт тайлбар өгч ажиллалаа.

Бусад:

- Сумдын нотариатын үүрэг гүйцэтгэгч нарыг цахим сургалтанд хамруулсан.
- Өмнөговь аймагт зохион байгуулагдсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах “Жендэр ба Хүний эрх” сургалтад мэдээлэл бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангасан.
- УИХ-н Тамгын газрын хянан шалгах хорооноос зохион байгуулсан хянал шалгалтын хүрээнд холбогдох байгууллагаас мэдээлэл авч тус хороонд хүргүүлэн ажиллав.
- Тайлангуудыг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав.
- Аймгийн ИТХ-аар Ханбаянзүрх хайрхан уул, хамарын хийдийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч, аялагчдын нийтээр дагаж мөрдөх журмыг эцэслэн боловсруулж хүргүүлэв.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Хэлтэст энэ сард нийт 65 албан бичиг ирж, хариутай 12 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, бусад 53 албан бичиг нь мэдээлэлд авах болон цаашид авч хэрэгжүүлэх, хугацаа болоогүй албан бичгүүд байсан. Үйл ажиллагааны болон хөрөнгө санхүүгийн чиглэлийн Засаг даргын нийт 7 захирамжийг батлуулж ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүх шатанд зохион байгуулж, 81.5 хувьтай хангаж ажилласан.

Бэлчээрийн төлөв байдал, ургац тодорхойлох судалгаагаар нийт нутгийн 39.5 хувь нь 50-100 хүртэлх хувийн бэлчээрийн нөөцтэй, 34.4 хувь нь бэлчээрийн даац 1-3 дахин, 7.5 хувь нь 3-5 дахин, 18.4 хувь нь олон дахин хэтэрсэн гэж тодорхойлогдсон.

Тус онд орон нутгийн 4665 малчин өрхийн 3,0 сая орчим толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвтэй байгаа ба одоогоор 758 өрхийн 475,7 мянган толгой мал өөрийн аймгийн бусад сумын нутагт оторлохоор зохион байгуулалтад ороод байан.

Аймгийн аюулгүйн нөөцөд 270 тн өвс, 61,5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 580.6 тн өвс 171.4 тн тэжээл, малчдын түвшинд 4322 тн өвс, 531 тн үйлдвэрийн тэжээл, 42 тн гар тэжээл, 58 тн ногоон тэжээл, 322 тн давс хужир шүү бэлтгэсэн.

Аймгийн аюулгүйн нөөцөөс 7000 боодол буюу 140 тн өвсийг Хөвсгөл сумын сум дундын агуулахад, 4216 боодол буюу 84,3 тн өвсийг Өргөн сумын агуулахад тус тус татан төвлөрүүлсэн.

Улсын Онцгой комиссын 4, 5 дугаар хуралдаанд орон нутгийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл, цаг үеийн мэдээлэл, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх хүсэлт тавьж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийг Дорноговь аймагт зохион байгуулж, 240 орчим төлөөллийг хамруулсан.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл сунгах, шинээр олгох тухай 1 удаагийн захирамжаар 12 аж ахуйн нэгжид холбогдох хариуг хүргүүлсэн.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжиж буй аймгийн дэд хөтөлбөр 5, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө, бусад тайлан мэдээг хугацаанд нь тайлагнасан.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр:

- Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын гишүүд Сайншанд сумын 8 дугаар багт 233, 245-р байрны баруун талын автозам барих, аймгийн Нэгдсэн эмнэлгийн цахилгаан шат угсарч суурилуулах, Сайншанд сумын 6 дугаар багт Жанчивын гудамжинд цэвэр усны шугам татах, Сайншанд суманд иргэн Б.Итгэлтийн захиалгаар баригдсан Үйлчилгээтэй орон сууц, Даланжаргалан суманд “МАК” ХХК-ийн 874.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан “Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц”-ны барилга, Замын-Үүд суманд Борхойн тал констракшн ХХК-ийн захиалгаар баригдсан худалдаа үйлчилгээний барилга, Хамарын хийд болон төв цэнгэлдэх хүрээлэнд боловсон ариун цэврийн байгууламж, Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний цахилгаан хангамж, нийт 9 барилгын ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь

танилцаж, холбогдох үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

- Барилга хот, байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээний судалгааг гаргаж хүргүүлсэн.

- Барилгын хөгжлийн төвд барилгын нэгдсэн мэдээллийн системд СӨХ-ийн бүртгэл хариуцах ажилтны мэдээллийг хүргүүлсэн.

- Барилга, хот байгуулалтын сайдын 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийн тайланг гаргаж хүргүүлсэн.

- “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого”-ын хүрээнд авах арга хэмжээний санал боловсруулсан.

- Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дэнжийн хэсэгт хуучин 2 барилгыг дахин төлөвлөлтөд оруулж 2023 онд “170 айлын орон сууц” барих төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөлт хийгдсэн.

- Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Дорноговь аймгийн Засаг даргын хооронд засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан 2022 оны гэрээний жилийн эцсийн тайланг бэлтгэсэн.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсөл арга хэмжээний саналыг боловсруулж урьдчилсан жагсаалтыг удидлагуудад танилцуулж, аймгийн ИТХуралд оруулах материалыг хүргүүлсэн.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 96 төсөл арга хэмжээнд 23,356,7 сая төгрөгийн, Замын сангийн 3 төсөл арга хэмжээнд 843,5 сая төгрөгийн, Их засварын хөрөнгө оруулалтын 8 төсөл арга хэмжээний 883,8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 5 төсөл арга хэмжээний 4,841,5 сая төгрөгийн, нийт өссөн дүнгээр 29,925.5 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээсэн.

Энэ сард тендерт шалгарсан 2 аж ахуй нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулах эрх үүссэн мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн цахим тендерээр 11 төсөл арга хэмжээний ажлыг зарласанаас 10 ажилд оролцогч орж, нэг ажилд буюу Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд оролцогч ороогүй.

Хил гаальтай холбоотойгоор ажил гүйцэтгэж байгаа компаниуд гэрээ сунгах 8 хүсэлт ирүүлсэнийг ГХБХГазраас дүгнэлт авч сунгахаар хүлээгдэж байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн 20 байгууллагаас сэтгэл ханамжийн судалгааг авч боловсруулалт хийж үр дүнг тооцож ажиллаж байна.

- “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын төлөвлөгөө”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн салбарын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтүүдийг гаргаж ЭМЯ, Авлигатай

- тэмцэх газарт хүргүүлээ. Үндэсний аюулгүй байдлын 2022 оны эрүүл мэндийн чиглэлийн тайланг гарган хугацаанд нь цахимаар хүргүүлэв.
- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дэмжлэгтэйгээр СЭМҮТ-ийн хүүхэд, өсвөр үеийн клиникийн эрхлэгчтэй хамтран 2022 оны 11-р сарын 07-11-ний өдрүүдэд Сайншанд, Замын-Үүд сумдын ЕБС-ийн сурагчдад ганцаарчилсан ярилцлага хийж, зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Сайншанд сумын 1, 2, 3, 4-р сургуулийн 49 сурагчдтай ганцаарчилсан ярилцлага хийж, 373 сурагчдад "Бухимдлаа тайлах арга", "Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтох эмгэгээс сэргийлэх нь" сэдэвт сургалт, Сайншанд сумын иргэдэд "Бухимдлаа тайлах арга зүй" сургалт, сургуулиудын 14 нийгмийн ажилтан, эмч нарт "Зонхилон тохиолдох хүүхдийн сэтгэцийн өвчлөл" сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.
 - Дорноговь аймгийн ЗДТГ, Боловсрол соёл урлагийн газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ерөнхий боловсролын сургуулиудад "БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэхэд, тулгамдаж буй асуудал"-ын талаарх хэлэлцүүлэг зохион байгуулагдах тухай албан бичгийг ЭМЯ-ны 6/4961 дүгээр албан бичгийн хамт хүргүүлэн 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, дүгнэлтийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны харьяа Нийтийн эрүүл мэндийн газарт 11 дүгээр сарын 17-ны өдөр албан бичгээр хүргүүлэв.
 - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхэд, өсвөр үеийн клиникийн эрхлэгч, эмчийг урин 2022 оны 11 дүгээр сарын 07-оос 11-ний хооронд 5 өдөр Сайншанд-Зүүнбаян, Замын-Үүд сумдад ажиллууллаа. Сайншанд, Замын Үүд сумдын ЕБС-дад 5 хоног ажиллан 8-16 насны 60 сурагчдад ганцаарчилсан ярилцлага хийж шинээр 11 өвчлөл илүүллээ. 327 сурагчдад "Мансуурах донгоос сэргийлэх нь", "Бухимдал тайлах арга" сэдвээр сургалт зохион байгуулж хүүхдүүдийн мэдлэг хандлагыг нэмлээ. Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран "Бухимдал тайлах арга зүй" сэдвээр 85 иргэнд сургалт зохион байгууллаа. Сайншанд, Замын-Үүд сумын сургууль, цэцэрлэгийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан нийт 25 хүнд "Хүүхдэд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгүүд" сэдвээр сургалт хийж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Сайншанд сумын Лабораторийн 2-р сургуулийн сэтгэл зүйч М.Буянцэцэг Айраг, Даланжаргалан суманд 2022 оны 11 дүгээр сарын 10-11 өдрүүдэд ажилласан. 2 сумын нийт 18 сурагчдад ганцаарчилсан ярилцлага хийж, 6-12 ангийн 162 сурагчдад "Уур бухимдлаа хэрхэн тайлах" сэдвээр, 28 албан хаагчдад "Стресс тайлах арга зүй" сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.
 - Хүүхдэд ээлтэй орон нутаг, Хүүхэд хөгжил-2022 зорилтот жилийн хүрээнд Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1, 3 дугаар сургуулийн дотуур байрны сурагчдад өсвөр үеийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хуваарь гарган 2022 оны 11 дүгээр сарын 17-ний өдөр Ерөнхий боловсролын 1 дүгээр дотуур байрны 63 /90%/ сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн. 2022 оны 11 дүгээр сарын 18-нд Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн дотуур байрны сурагчдад үзлэг зохион байгуулсан.

- Үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 10 дугаар ангийн 68 сурагчдад өртөөчилсөн сургалт, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн дотуур байрны 27 хүүхдэд нийт 95 сурагчдад амны хөндийн эрүүл мэнд, НҮЭМ сэдвээр мэдлэг олгосон.
- Оюутан, залуусыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгын хүрээнд “Эрүүл оюутан-Эелдэг хандлага” уриатайгаар “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”-ын аяны төлөвлөгөөг Дорноговь аймаг дахь АШУҮИС-ийн салбар сургууль, Политехник коллежтэй хамтран боловсруулан 16 заалтын хүрээнд 93%-тай хэрэгжүүлэв. Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяныг зохион байгуулах Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/605 дугаар захирамжаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг ЭМС-ын А/139 дүгээр тушаалын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгтэй хамтган зохион байгуулж АШУҮИС Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 129 оюутан (100%), Политехник коллежийн 319 оюутан (95.5%) нийт 1 дүгээр курсын 463 оюутнаас 448 буюу 96.7% оюутныг үзлэг шинжилгээнд хамруулж 112 /25%/ оюутны эрүүл мэндийн өөрчлөлтийг илрүүлж, эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Нийт үзлэгт шүдний цооролтой оюутан 54%-ийг эзэлж Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран Политехник коллежийн оюутнуудын амны хөндийг эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулан 2022 оны 11 сарын 10-ний өдрийн байдлаар 45 оюутны шүдийг эмчлэн эрүүлжүүлээд байна. Сарын аяныг идэвхижүүлэх зорилгоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 7 ангийн оюутнууд “Эрүүл биед саруул ухаан оршино” flash mob challenge, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж оюутнуудын эрүүл мэндийн даатгал төлөлт 43.5% байсныг 80% хүртэл нэмэгдүүлж ЭМС-ын А/139 дүгээр тушаалын дагуу эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт 1-6 дугаар курсын нийт 551 оюутныг урьдчилан сэргийлэх хамруулж үүнээс өвчтэй 286 оюутныг илрүүлж 10.3% эрүүлжүүлээд байна. Аяны хүрээнд 18 сэдвийн хүрээнд 754 оюутанд өртөөчилсөн болон цахим, танхим хэлбэрээр эрүүл мэндийн боловсрол олгосон. Сарын аяны хугацаанд сахуу татрангийн 2 дахь тун вакцинд 15 настай 173 оюутныг хамруулсан.
- Төрийн болон хувийн хэвшлийн шүдний эмч нартай хамтран Сайншанд сумын 13 цэцэрлэгийн 3-5 насны 1065 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж шүдний өвчлөлтэй 591 хүүхдийг илрүүлж 1, 2, 4, 6, 9, 12 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдийн шүдний цоорлын эрчим 2.78, цоорлын тархалт 48.1 байгааг тогтоосон. Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 1106 хүнд зохион байгуулж мэдлэгийг нэмэгдүүлсэн.
- 2022 оны 46 дугаар 7 хоногт аймгийн хэмжээнд амбулаториор 8241 хүн үйлчлүүлсний 1112 (13.5%) нь Коронавируст халдвар(КОВИД-19) болон томуу томуу төст өвчин (ТТӨ) эзэлж, өмнөх 7 хоногоос 1.1%-иар буурсан байна.
- Амбулаториор үйлчлүүлэгсдийн дунд ТТӨ 10000 хүн амд 154.2 промил, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоог 10000 хүн амд харьцуулахад 5.1

- болж АЗЦХХ шалтгаант болон улирлын томуугийн цар тахлын эрсдэлийн үнэлгээгээр “АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТ”-д байна.
- Зохистой хооллолт, Хөдөлгөөн эрүүл мэнд сэдвээр “Чандмань-Илч”ХХК-ийн 46 ажилтанд сургалт зохион байгуулсан.
 - “Залуучуудаа сонсох өдөр”-ийн хүрээнд Манлайллын эхлэл хөгжлийн төвийн багш Д.Мөнх-Эрдэнэтэй хамтран Харилцаа хандлага, Хувь хүний хөгжил сургалтыг танхим-36, цахимаар-26 нийт 62 эрүүл мэндийн салбарын залуучуудыг хамруулсан.
 - БШУГ-тай хамтран “Эрүүл аж төрөхүй” Эрүүл мэндийн анхдугаар олимпиадыг Сайншанд сумын 5 сургуулийн 7,8,9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан.
 - ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албанаас “Элэг бүтэн хөтөлбөрийн хэрэгжилт”-д үнэлгээ хийж ЭМГ, АНЭ, өрхийн эрүүл мэндийн төвийн 20 эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулаа
 - “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ОНОШИЛГОО”-нд 2022 оны 05 сарын 01-нээс 12 сарын 02-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 23.8% буюу 17134 иргэд хамрагдсан. Үүнээс 73.9% /12665/-ийг 0-17 насны хүүхэд, 26.0% /4469/-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна. Сүүлийн 7 хоногт / 11 сарын 25-наас 12 сарын 02 / сум, өрхийн ЭМТ-үүд 0-17 насны 609 хүүхэд, лавлагаа шатлалд 18-аас дээш насны 48 хүн нийт 657 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.
 - Аймгийн Цагдаагийн газартай хамтран автозамын хөдөлгөөнийг зохицуулан, аюулгүй байдлыг хангаж, ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдрийг тохиолдуулан “Тэгш байдлыг хангая! Хүн бүр оролцъё!” уриан дор өсвөр үе, залуучуудын нөлөөллийн алхалт зохион байгуулж Дорноговь аймгийн ерөнхий боловсролын 1 болон 3-р сургуулийн ахлах ангийн сурагчид, Онцгой байдлын газрын албан хаагч нар, Агатова, Мишээлт мана өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамт олон нэгдэж, нийт 86 хүн оролцож, аймгийн нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинетын эмчтэй хамтран БЗДХ/ХДХВ/ДОХ-ын өвчлөл, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ерөнхий боловсролын 2 болон 3-р сургуулийн ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа.
 - Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах 6 материал, шинээр эмийн сан 2 төсөл, эм ханган нийлүүлэх 1 төслийн материалуудыг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, Тусгай зөвшөөрөл олгох аймгийн салбар комиссын хурлаар хэлэлцүүлэв.
 - “Чанарыг эрхэмлэгч” тэмдэг олгох журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулан эмч мэргэжилтнүүдэд хэлэлцүүлэн, ЭМГ-ын 2022 оны А/139 тушаалаар шинэчлэн баталж, ЭМБ-уудад хүргүүлсэн.
 - “Дэлхийн чанарын өдөр” ийн хүрээнд ЭМХТ-өөс зохион байгуулсан “Тусламж, үйлчилгээний чанарын асуудалд” сэдэвт цахим сургалтад ЭМБ-ын чанарын багийн дарга, гишүүд, эмч мэргэжилтнүүдийг хамруулав
 - Эрүүл мэндийн байгууллагууд “Үйлчлүүлэгчид ээлтэй –Сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийн зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд иргэдэд гэрийн сувилгаанд ашиглаж буй эмнэлгийн хэрэгсэл, болон гарын доорх материал ашиглан хийсэн асаргааны иж бүрдлээ танилцуулан асаргаа сувилгаа зааж, зөв зохистой хоол хүнс, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх иллэг, эрүүл боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан. Нийт 478 хүнийг хамруулж 4 төрлийн 569 ш гарын авлага бэлтгэн тараасан.

- ЭМЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийн чанарын холбоотой хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багийн гишүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал" сэдэвт онол дадлага хосолсон 2 өдрийн сургалт зохион байгуулж, 23 байгууллагын 48 эмч мэргэжилтнүүдийг хамрууллаа.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын сувилагч нарт аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн алба, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуультай хамтран хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, тариа болон дуслын автомат шахуурга хэрэглэх заавар зэргээр дадлага, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилахуйн түүх хөтлөлт, халдвар сэргийлэлт, хяналт сэдвүүдээр онолын сургалтыг зохион байгуулж мэдлэгийг бататгалаа
- Дэлхийн дутуу төрөлтийн өдрийг тохиолдуулан хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн Б.Баясгалантай хамтран "Дутуу нярайн тусламж, үйлчилгээний онцлог" сэдвээр цахим сургалт зохион байгуулагдан нийт нарийн мэргэжлийн 7 эмч мэргэжилтэн хамрагдав.
- Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төвийн их эмч Сүхбаатартай хамтран Уламжлалт анагаах ухааны яаралтай тусламж, томуугаас урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих хооллолт сэдвүүдээр анхан шатны ЭМБ-ын эмч мэргэжилтэнд цахим сургалт хийсэн.
- Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилт үүсэхээс сэргийлэх нэг сарын аяны хүрээнд Эрүүл мэндийн газраас Аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн 500 жорыг эмийн сангуудаас татан авч Эмийн жорын маягт, жор бичилтийн MNS5376:2016 стандартын дагуу үнэлгээ хийлээ. Үнэлгээний дагуу гарсан үр дүнг өрх, нэгдсэн эмнэлгийн эмч нарт танилцуулж, алдааг залруулж, жор бичилтийг сайжруулах зорилгоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн Эм судлалын багш Даваачимэг, Энхтуул нартай хамтран жор бичилтийн сургалт зохион байгуулж, 52 эмч хамрагдлаа. Сарын аяны тайланг нэгтгэн ЭЭХХЗГ-т хүргүүлсэн.
- "ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ, ТАНДАЛТ" сэдэвт танхимын сургалтыг төр хувийн хэвшлийн 22 эрүүл мэндийн байгууллагын ХСХ-ын багийн гишүүдэд онол болон ажлын байрны дадлага хосолсон сургалт зохион байгууллаа .

СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Биеийн тамир, спортын газрын жүдо бөх, чөлөөт бөх, бокс, сагсан бөмбөгийн дугуйлан, фитнесс, усан спорт сургалтын төв хэвийн хичээллэн ажиллаж байна.

- “Нөхөрлөл лиг” сагсан бөмбөгийн тэмцээн 11 дүгээр сарын 01, 08, 15, 22, 29-ний өдрүүдэд тус тус болов. 11 дүгээр сарын 05-ны өдөр “Нөхөрлөл лиг” сагсан бөмбөгийн тэмцээний 2022-2023 оны улирлын нээлтийн арга хэмжээ 11 дүгээр сарын 05-ны өдөр Спорт цогцолборт болов.
- Аймгийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар хамтран Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангиудын сурагчдын дунд зохион явуулсан “Флаш моб” тэмцээн 11 дүгээр сарын 04-ний өдөр Спорт цогцолборт боллоо. Ерөнхий боловсролын сурагчдын дунд хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлгөөний ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, хөдөлгөөнөөр дамжуулан хүүхдийн биеийн дархлааг сайжруулах зорилгоор “Флаш моб” тэмцээнийг зохион байгуулсан. Уг тэмцээнд 20 багийн 300 гаруй сурагчид оролцсоноос:

Ахлах ангийн төрөлд:

Сайншанд сумын ЕБ-ын Шинэ эхлэл 5-р сургууль тэргүүн байр,
ЕБ-ын 2-р сургуулийн “Говийн уянга-7” баг 2-р байр, ЕБ-ын 1-р сургуулийн “Уран дэг-2-2” баг 3-р байр, Тусгай байрыг 1-р сургуулийн “Уран дэг-2” баг тус тус эзэллээ.

Дунд ангийн төрөлд:

Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн “Уран дэг-3” баг тэргүүн байр,
2-р байранд Шинэ эхлэл 5-р сургуулийн баг, 3-р байранд Хөвсгөл сумын “Хутагтын дэг” баг,

Тусгай байранд 2-р сургуулийн “Говийн уянга-9” баг тус тус шалгарсан байна.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Грассрүүтс хөлбөмбөгийн анхан шатны тэмцээний нээлт 11 дүгээр сарын 05-ны өдөр Спорт цогцолборт болсон. 11 сарын сүүлийн 7 хоногт Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургуульд зохион байгуулагдаж, 5 бүлгийн 80 сурагч, Замын-Үүд сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн 120 сурагч, Алтанширээ сумын ЕБ-ын сургуулийн 101 сурагч 8,10,12 насны ангилалд тус тус өрсөлдсөн.
- Спорт цогцолборт 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд албан байгууллагуудын аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн боллоо.
- Цагдаагийн газраас хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам 2022” тэмцээнийг 11 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Улаан загалмайн нийгэмлэг, Боловсрол, шинжлэх ухааны газар, Автосургуулиуд, эм холбоо Дорноговь салбар зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 13 баг оролцсон.
- Нийгмийн даатгалын салбарын Зүүн бүсийн уулзалт, спортын арга хэмжээ Спорт цогцолборт 11 дүгээр сарын 17-ны өдөр болж өндөрлөлөө.

- Дорноговь аймгийн Ажил олгогч эздийн холбооны спортын арга хэмжээ Спорт цогцолборт 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдлаа.
- УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын санаачилгаар зохион байгуулсан Монголын Волейболын дээд лигийн тойргийн тоглолт 11 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.
- 2022 оны өсвөр үеийн аварга шалгаруулах гандболын тэмцээн 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Спорт цогцолборт боллоо.
- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.
- Соёл урлагийн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан "Соёл, урлагийн салбарын ёс зүйн зөвлөл" хуралдаж, 2022 оны сүүлийн улирал болон 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцлээ. Мөн холбогдох хууль эрх зүй, дүрэм журмыг ажилтан албан хаагчдад сурталчлах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан.
- Төв номын сан болон Өргөн, Эрдэнэ сумдад Зөвлөн туслахаар ажиллаж сайжруулах шаардлагатай ажлуудыг зөвлөмжөөр хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлтийн тайланг хүлээн авсан. Албан хаагчдыг ажлын байран дээр сургах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Соёл, урлагийн газрын мэргэжилтнүүд сургалт мэдээлэл, ярилцлага хэлэлцүүлэг явууллаа. Зөвлөн туслах ажлыг дараах чиглэлээр зохион байгуулсан.
- Монгол улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулагдсан "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ" сургалтад хамрагдсан СУХэлтсийн дарга Б.Хүдэрчулуу эмэгтэй албан хаагчдадаа манлайлал, коучийн ур чадвар, ажил амьдралын тэнцвэр, төрийн алба ба карьер төлөвлөлтийн талаар сургалт орсон.
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулах ажлын хэсэг Дорноговь аймгийн 14 сумын нутагт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж ажиллаа.
- Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан “Гэр бүлээрээ” боловсролын хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд байгууллагын захирлын А/24 дүгээр тушаалаар 399,600 төгрөгийг зарцуулсан. Энэхүү боловсролын хөтөлбөр арга хэмжээнд ЕБ-ын сургуулийн 5 сурагч эцэг эхийн хамт оролцож хоол хийсэн. Мөн аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Эрүүл зохистой хооллолт” сэдвээр мэдээлэл 21 хүнд хүргэсэн.
- Музейн дэргэдэх “Museum shop” ажиллуулж байна. Эсгий гар урлалын, бэлэг дурсгалын зүйлс зэрэг 30-аад бүтээгдэхүүн тавигдсан.
- Байгууллагын захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар Монгол Улсын Их Сургуулийн Археологийн судалгааны төвтэй хамтран Мандах сумын Өехий багийн нутаг дахь Дэнгийн овоо орчимд археологийн малтлага, судалгааны зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Уг судалгааны ажилд 6,331,400 төгрөгийг Эрдэм шинжилгээний ажлын зардлаас гарган зарцуулав.

- Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Музей сургалт судалгааны төв, МУЭ-ийн Дорноговь аймгийн салбар хамтран “БАГШ-2022” хамтарсан үзэсгэлэн гарч байна. Үзэсгэлэн 1091 сурагчид үзсэн.
- Дорноговь аймгаас төрөн гарсан хөгжмийн зохиолч, ая зохиогчид, яруу найрагчдын уран бүтээлийг олон түмэнд сурталчлах түгээн дэлгэрүүлэх, шинэ авьяастнуудыг нээн хөгжүүлэх зорилгоор “Хутагтын говиос эгшиглэсэн аялгуу цадиг” шинэ шилдэг уран бүтээлийн дуун цэнгүүнийг 2022.12.02-нд “Хутагтын шүншигтэй аялгуу” дууны уралдааныг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- 2022 оны 10 сарын байдлаар танхимаар 1055, уншигч, ирэгсэд 1213, Танхимаар ном олголт - 1490, гэрээр ном олголт -170 олгож үйлчилсэн. 114 ширхэг ном нааж сэлбэсэн, Уншигчийн карт нээсэн - 55, Зөврөөр ном олголт 193, Үзэсгэлэнд гаргасан ном -242, “Аз жаргалын өрөө”-нд 85 хүүхэд хамрагдсан. Хэвлэл захиалга 90ш ном, Сэдэвчилсэн лавлагааг 97 удаа өгч уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллалаа.
- Сумдын номын санч нар болон аймгийн төвийн сургуулийн номын санч нарт “Номын сангийн анхан шатны бүртгэл” сэдвээр цахим сургалт явуулсан. Сумдын 18 номын санч сургалтад хамрагдсан. Долоо хоног бүрийн даваа гаригт цахимаар холбогдон хамтын ажиллагааг сайжруулахаар боллоо.
- Эрдэнэ сумын Хилийн цэргийн 0129-р ангийн ажилтан, албан хаагч, шинэхэн цэргүүдэд “Номыг шинжихүй” сэдэвт монголын нууц товчооны талаар мэдээлэл хийж нээлтэд нууц товчооны 12 ширхэг хэвлэгдсэн номоор мөн 2022 онд шинээр ирсэн номын дээжээр үзэсгэлэн гаргасан.
- Уяа зангилааны соёл сургалт явуулж 2 сургагч багш ажиллаж 88 гаруй хүн хамрагдаж эхний 3 байрыг шалгаруулж урамшуулсан.
- “Цагаан идээг яаж боловсруулдаг вэ?” танин мэдэхүйн хөтөлбөрт 25 хүүхэд хамрагдсан.
- Америкийн Соёл мэдээллийн Соёмбо номын сангийн үйл ажиллагаанд нийт 456 иргэн үйлчлүүлсэн байна.
- ОУ-н багш нарын баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд “Багш бадрахуй” хөтөлбөрийг 10 сарын 1-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Манай төвийн хөтөлбөр аймаг сумдын нийтдээ 24-н Англи хэлний багш хамрагдсан . АНУ-н санхүүжилттэй зохион байгуулагддаг багш нарын болон ахлах ангийн сурагчдын мэргэжил дээшлүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл хүргэсэн.
- Сайншанд сумын ЕБ-н сургуулиудад 2021 оны FLEX хөтөлбөрийн төгсөгч 5-р сургуулийн сурагч Г.Пүрэвдарьтай хамтран сурагчдад мэдээлэл хүргэлээ. Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагаа болон АНУ-н санхүүжилттэй ахлах ангийн сурагчдын FLEX тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хүсэлт гаргах, тэтгэлгийн эссэг хэрхэн сайн бичих тухай зөвлөгөө өгсөн.

- Английн Лийдсийн Их Сургуулийн магистр, доктор, Удирдлагын академийн багш, дэд профессор Ж.Нарантуяа болон түүний охин Канадын Бритиш Колумбын Их Сургуулийн магистр Б.Цэрэнбалжир нар Америкийн

Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжин, өөрсдийн зохиож, орчуулсан англи хэлийг шамдан суралцагсдад нэн шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлагыг хандивласан.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 542.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Орон нутгийн төсвийн байгууллагад 501.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 75.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 42.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 33.1 тэрбум төгрөгөөр орлого тасарч 55.3 хувийн биелэлттэй гарсан.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд 2022 оны 11 сарын 01-11 сарын 30-ны хооронд нийт 2316 гүйлгээний 7.8 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудас анхан шатны баримтын бүрдлийг хянаж Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан ажилласан.
- Нэмэлт санхүүжилтийн 45 байгууллагын хүсэлтийг үндэслэн 568.9 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн төсвийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 10 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.
- Орон нутгийн 2023 оны төсвийн төслийг Төрийн аудитын газарт хүргүүлж дүнэлт зөвлөмжийн хариуг албан бичгээр хүргүүлсэн.
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд байгууллагын дарга чөлөөлөгдөн, шинээр томилогдсон 5 дарга, 6 нягтлан бодогчийн хүсэлтийг үндэслэн баталгаажуулан ажилласан.
- Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 11 сумын 24 ажлын 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн баримтын бүрдлийг хянаж Засаг даргын зөвшөөрлөөр олгосон.
- Санхүүгийн зохицуулах хороо, Гүүдсек үнэт цаасны компанитай хамтран “Хамтаараа баяжих тун” сэдэвт эвент, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Шинээр байгуулагдсан 2 аж ахуйн нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн e-balance системд бүртгэн анхаарах асуудлуудын талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.
- Шилэн дансны цахим систем шинэчлэгдэж байгаатай холбогдуулан орон нутгийн 148 байгууллага бүртгүүлэхээс 131 төсвийн байгууллага бүртгүүлэн 88.5 хувийн биелэлттэй байна.
- Ахмадын сангийн данс шинээр нээлгэх хүсэлтийг Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Шүүхийн тамгын газар, Сайхандулаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ирүүлсэн тул Сангийн яамны Төрийн

сангийн газарт албан бичиг хүргүүлэн төрийн санд бүртгэлийн дансыг нээлгэж ажилласан.

- Портал системийн цахимжуулалтын туршилт нэвтрүүлэлтийн төлөвлөгөөний дагуу 6 байгууллага нэвтрүүлэхээс 2 байгууллагын төлбөр тооцоог цахимаар хийж гүйцэтгэсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхижуулах сургалтад хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн хамрагдсан.
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэлтэй эд хөрөнгийг Нийтлэг үйлчилгээний газарт балансаас балансад шилжүүлэх, 2 автомашин ашиглалтын шаардлага хангахгүй, үлдэх өртөггүй болсон тул тус хөрөнгийг акталж, худалдан борлуулахаар хүсэлтийг холбогдох газарт хүргүүлсэн.
- Боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх Хилийн боомтын захиргаа байгуулагдсантай холбогдуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчдын ажиллах, нөхцлийг бүрдүүлэх талаар аймгийн Засаг даргын захирамжийг гаргасан.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц.

- Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

Цаг үеийн ажлын мэдээлэл:

- Монгол Улсын Сангийн сайдын СХШХ/06 тоот удирдамж болон албаны даргын 13 тоот удирдамжийн дагуу Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, усны үнийн дүнгийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой тухайн үйлчилгээг үзүүлсэн аж ахуйн нэгжийн төрөөс нэхэмжилсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн төлбөр тооцоонд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэн, шалгалтын тэмдэглэл, улсын ахлах байцаагчийн акт, холбогдох баримтыг Сангийн яаманд хүргүүлсэн.
- Албаны даргын баталсан 14 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын тэмдэглэлийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 187 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.
- Албаны даргын баталсан 15 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.
- Актын төлбөрийн үлдэгдлээс 6,9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц.

- Улс ба орон нутгийн төсөвт 3.2 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 7 төрлийн нийт 999 татварын тайлан, 1081 хүсэлтийг хүлээн авч ажилласан. Тайлант сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 962, өрөөгөөр 1023 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийж үйлчилгээ үзүүлсэн.
- 2022 оны 11 сард 119 татвар төлөгчдөд нэхэмжлэл хүргүүлсэн. Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 8 хуулийн этгээдийн мэдээллийг баазад бүртгэж ажиллалаа. НӨАТ суутган төлөгчөөр 10 хуулийн этгээдийг бүртгүүлсэн.
- Татвар төлөгчдөөс дуудлагаар 128 гомдол хуваарилж, 137 гомдлыг шийдвэрлэсэн.
- Эрдэнэ, Өргөн, Дэлгэрэх, Алтанширээ, Иххэт, Даланжаргалан сумдад “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөгт Татварын байцаагч хариуцсан чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаагаа сурталчилж, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, үйлчилгээ үзүүллээ.
- Аймгийн ажил олгогчдын зөвлөгөөний хөтөлбөрийн дагуу Татварын хууль эрх зүйн талаар 25 ажил олгогчдод зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 10 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан.
- Гол нэр төрлийн 32 бүтээгдэхүүн болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивэн, хугацаанд нь дамжуулав. Мөн 14 сумын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн мэдээллийг сумдын мэргэжилтнүүдээс авч нэгтгэн танилцуулга бэлтгэн хэлтсийн цахим хуудсанд байршуулж, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар тархаасан.
- Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдаас 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг судлан программд шивж Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-3Г-1, А-3Б-1/, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, бизнес регистрийн бүртгэлийн БР-1 мэдээ, хөдөө аж ахуйн /ХАА-3, ХАА-9, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж дамжуулсан.

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны 4,5 сарын мэдээлэл цуглуулалтыг Өргөн, Замын-Үүд, Сайншанд сумдаас 48 өрхийг хамруулж, мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж Үндэний Статистикийн хороонд дамжуулаад байна.
- Статистикийн байгууллагын 98 жилийн ойг угтан 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр АШУИС-ын Дорноговь аймаг дахь Анагаах ухааны их сургуулийн оюутан, ЕБ-ын 5-р сургуулийн сурагчдад “Статистикийн боловсрол” сургалтыг зохион байгуулав. Сургалтын үеэр Статистикийн байгууллагын үүсэл хөгжил, үйл ажиллагаа, статистик мэдээллийн хэрэглээ, ашиглалт, нэгдсэн мэдээллийн сан 1212.mn, хэлтсийн вэб хуудасны талаар мэдээлэл хийж, сургалтанд 160 орчим, оюутан, сурагчид хамруулсан.
- Сайншанд сумын Статистикийн мэдээний мэдээлэгч нарт зориулсан сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулав. Сургалтад зочид буудал, зоогийн газар, аж үйлдвэр, төрийн бус байгууллага, сүм хийд зэрэг салбарын мэдээний мэдээлэгч нарын төлөөлөл 11 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл захирал, нягтлан бодогч нар хамрагдаж, Статистикийн байгууллагын үүсэл хөгжил, хууль эрх зүй, мэдээлэгчийн эрх үүрэг, албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах хугацаа, анхаарах асуудал, мэдээ тайлангийн боловсруулалт, тархаалт зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл хийсэн.
- Монгол улсын “Статистикийн тухай” болон “Зөрчлийн тухай” хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, статистикийн мэдээ тайлангийн үзүүлэлтийг зөв ойлгох, маягтыг зааврын дагуу бүрэн нөхөх, баталгаажуулах, бодитой байдлыг хангах чиглэлээр 11 сарын 01-нээс 11 сарын 10-ны өдрүүдэд Сайншанд сумын статистикийн үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт, үнэлгээ хийв. Хяналт хийсэн ажлын илтгэх хуудсыг Сайншанд сумын Засаг даргын орлогч, Захирагчийн ажлын албаны дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөө аж ахуйн тасгийн дарга, мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нарт танилцуулж, зөвлөмж чиглэл өгсөн.
- Мал тэжээвэр амьтад хашаа худгийн 2022 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн тооллогын комиссыг байгуулсан захирамж, мал тооллогыг зохион байгуулах тухай албан бичиг, маягтын хуваарилан сумдад хүргүүлсэн.

ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт
Нэг. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр:		
1	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтлөх, удирдлагуудад танилцуулах,	Засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 2, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 1, нийт 8 тогтоол шийдвэр, тушаалыг хяналтад авч, бүртгэл хөтлөн удирдлагуудад

	хэрэгжилтэд хяналт тавих	танилцуулсан.
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:		
2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар захирамжийг шинэчлэн баталгаажуулах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/280 дугаар захирамжийг хүчингүй болгон, шинээр 2022 оны А/675 дугаар захирамжаар баталгаажуулан, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын 25 агентлаг, 4 байгууллага, 14 сумын Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлсэн.
3	Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй дэд болон зорилтот хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх	Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй 9 дэд, 3 зорилтот хөтөлбөрөөс засаглал, хууль эрх зүйн чиглэлээр 3, соёл, соёл, эрүүл мэнд, боловсрол, ниймийн хамгааллын чиглэлээр 4, байгаль орчны чиглэлээр 3, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр 2 хөтөлбөрийн хэрэгжсэн бөгөөд нийт 12 тайлангийн жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэн дундажийг 93%-тай хэрэгжсэн байна гэж үнэлэн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ХШҮ тайланг бэлтгэн хүргүүлсэн.
4	Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8 зорилтын 114 арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг нэгтгэн, 89,4%-тай хэрэгжсэн байна гэж үнэлэн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ХШҮ тайланг бэлтгэн хүргүүлсэн.
5	Аймгийн Засаг даргын “хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх	Аймгийн Засаг даргын Хөгжлийн төлөө хамтдаа-2” /2020-2024 он/ үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 2 нэгж, 14 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, 4 төсөвт байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэсэн. Тус бодлогын баримт бичгийн 6 зорилтын 283 арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн, зорилт арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлант оны хэрэгжилтийг 92,2%-тай хэрэгжсэн байна гэж үнэлэн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ХШҮ

		тайланг бэлтгэн хүргүүлсэн.
6	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/05 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 2 нэгж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгуулллагууд, 14 сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлснийг нэгтгэсэн. “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 6 зорилтын 231 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн, 94,5%- тай хэрэгжсэн байна гэж үнэлэн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ХШҮ тайланг бэлтгэн хүргүүлсэн.
7	Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланд хяналт-шинжилгээ, үнэдгээ хийэ ЗГХЭГ-т хүргүүлэх	Орон нутагт хамаарал бүхий 18 заалт арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 96,1%-тай хэрэгжүүлэн ажилласан байна гэж дүгнэн, 2/1664-1 албан бичгээр хүргүүлэхийн зэрэгцээ цахим санд баталгаажуулсан.
<i>Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр:</i>		
8	Шинээр томилогдсон болон албан тушаал өөрчлөгдсөн албан хаагчдын судалгааг гаргах, хяналт-шинжилгээний үнэлгээний цахим санд ажиллах эрх нээлгэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй хүмүүсийн судалгааг авч, ажлаас чөлөөлөгдсөн 25 хүний судалгааг нэгтгэн, хасалт хийлгэсэн, шинээр нийт 8 албан хаагчдын мэдээллийг “Ухаалаг засаглал ТББ”-руу илгээж, нэвтрэх, тайлагнах эрхийг үүсгэсэн.
<i>Дөрөв. Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:</i>		
9	Хэлтсийн сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлж ажиллах	Хэлтсийн 11 сарын төлөвлөгөөг боловсруулан, ЗДТГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хяналтад авч ажилласан. 7 хоног бүрийн тайланг нэгтгэн, хамт олны мэдээллийн цагаар танилцуулсан. Сарын тайланг нэгтгэн, ТЗУХ-т хүргүүлсэн
10	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг шуурхай хийж гүйцэтгэх	ХШҮ-ний цахим санд Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хуваарилагдсан заалт арга хэмжээг хугацаанд нь баталгаажуулж ажилласан. Зүүнбаян Ханги мандлын чиглэлийн төмөр замын нээлтийн бэлтгэлийн үйл ажиллагаанд 1 мэргэжилтэн оролцсон. Сумдын Засаг даргын хурал, болон агентлагийн дарга нарын хуралд “Тайланд гарч

		буй алдаа дутагдал, анхаарах асуудал, хариуцлага” сэдвээр мэдээлэл бэлтгэн хүргэсэн.
11	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, ирсэн албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдэд “Бодлогын баримт бичгийг хяналтад авах нь”, “Төлөвлөлт болон тайлагналт”, “Хэлтсийн чиг үүрэг” сэдвээр сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангасан Хэлтэст ЗГХЭГ-аас 2 албан бичиг ирснийг хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Жилийн эцсийн тайлантай холбогдуулан сум агентлагаас 29 албан ирснийг бүртгэн, хяналтад авсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР